



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 9 сарын 05 өдөр

Дугаар 347

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас
балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Багануур-А33А” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 98,695,500.00 (ерэн найман сая зургаан зуун ерэн таван мянга таван зуун) төгрөгийн балансын үнэ, 84,162,015.00 (наян дөрвөн сая нэг зуун жаран хоёр мянга арван таван) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг “Талын зам” төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. “Багануур-А33А” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал А.Алтангадас, “Талын зам” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Т.Бямбадорж нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;


2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА




Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0002100

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2018 оны 09 дугаар сарын 05 - ны өдрийн 377
 дүгээр тогтоолын хавсралт



"Багануур-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн балансаас шилжүүлэх үндсэн хөрөнгийн жагсаалт

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Ашиглал тад орсон он	Тоо шир хэг	нийт гүйлт	Балансын дүн (төгрөгөөр)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөгөөр)	Үлдэгдэл өртөг (төгрөгөөр)	Хүлээж авах байгууллага
1	ISUZU маркийн, 98-18 БРА улсын дугаартай, тусгай тоноглолтой тээврийн хэрэгсэл	2007	1	2656	98,695,500.00	84,162,015.00	14,533,485.00	"Талын зам" ТӨХК
					98,695,500.00	84,162,015.00	14,533,485.00	
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		1 (нэг)		98,695,500.00 (ерэн найман сая зургаан зуун ерэн таван мянга таван зуун)	84,162,015.00 (наян дөрвөн сая нэг зуун жаран хоёр мянга арван таван)		